



12th Story

ЭЦЭГ ХҮҮГЭЭ ХҮЛЭЭДЭГ

Prodigal Son

Эцэг Хүүтээ хүлээдэг

– 12nd Story –



Өгүүлэгч

Өнөөдөр ч гэсэн Есүс ирсэн бүх хүмүүст Бурханы хаанчлалын тухай зааж байв. Гэтэл фарисайчууд, хуулийн багш нар Есүсийг гэм нүгэлтнүүдтэй хамт байх нь маш зохисгүй гэж бодоцгоосон. Есүс тийм бодол тээсэн фарисайчууд, хуулийн багш нарт зүйрлэлээр ингэж айлдав.

Есүс

Нэгэн хүн 2 хүүтэй байжээ. Нэгэн өдөр бага хүү нь эцэгтээ хэлэв.

Бага хүү

Эцэг минь, би танаас өвлөн авах хөрөнгөө авмаар байна.

Эцэг

юу гэнээ?

Бага хүү

тиймээ, яагаав дээ, таны хөрөнгөнөөс таныг нас барвал надад өгөгдөх хувь байгаа шүү дээ. Тэрийг өгнө үү.

Эцэг

аа .. тэгэхээр ... хүү минь, аав нь одоохондоо өвдөөгүй байна~

Бага хүү

тиймээ мэдэж байна. Би гэсэн одоо таныг үхэхийг хүсээгүй байна. Зүгээр л тэртээ тэргүй авах юмыг одоо авахыг хүссэн юм.

Эцэг

аа тийм байх нь ... тэгвэл тэг дээ

Есүс

Эцэг нь бага хүүдээ өгөх хөрөнгийг урьдчилж өгөв. Хэд хоногийн дараа бага хүү нь мөнгөө аваад хол газар аялалд гарчээ.

Бага хүү

За, одоо би ингээд ертөнц рүү явлаа. Би явахыг хүссэн бүх газраараа явж ханатлаа аялана, идэхийг хүссэн бүгдийгээ авч иднэ. Би хаан шиг амьдарна. Гоё доо~, баяртай~~

Эцэг

сайн яваарай хүү минь ...

Есүс

Бага хүү нь хэлсэн ёсоороо хийхийг хүссэнээ бүгдийг хийв. Үнэтэй хоолны газар орж ханатлаа захиалж идээд, мөнгөө ус хэрэглэдэг шиг хэрэглэсэн бөгөөд үргэлж эмэгтэйчүүдтэй хамт яван үнэтэй бэлгийг хайр найргүй худалдаж авч өгдөг байв. Бүр өөрөө худалдаж авч өгснөө ч санадаггүй байлаа. Замбараагүй амьдралаар хэсэг хугацааг өнгөрөөж байгаад нэгэн өдөр халаасанд нь нэг ч мөнгөгүй болсноо мэдэв.

Есүс

Ширхэг зоос ч байсангүй. Гэдэс нь өлсөж бүрмөсөн ядуурчээ. Бага хүү нь хаана ч очсон хоол авч идэх мөнгө олчихно гэж бодсон. Энд тэндгүй ажил хайсан боловч олсон ажил нь хөдөөний фермд гахай хооллох ажил байв.

Бага хүү

уучлаарай. Надад хийж чадах ажил байхгүй биз? Надад үнэхээр мөнгө хэрэгтэй байна.

Тариачин

мм .. байхгүй

Бага хүү

Гуйж байна. Ямар ч ажлыг бүгдийг хийнэ.

Тариачин

Хмм за яахав, тэгвэл гахай хооллоорой

Бага хүү

Гахайд хоол өг гэж үү? Би ...

Тариачин

дургүй бол боль л доо

Бага хүү

үгүй ээ, гахай хооллодог ажлыг бол хийж чадна. Том ажил шүү!!

Есүс

Бага хүү тэр ажлыг хийсэн боловч мөнгө хурааж чадсангүй. Хоол ч хангалттай авч идэж чадахгүй үргэлж гэдэс нь өлсдөг байв. Бас түүнд хэн ч тусалсангүй.

Бага хүү

Аа, үнэхээр хэцүү юмаа.. энэ гахайнууд муухай үнэртэй, надаас хүртэл үнэр ханхалж байна, балиар юм! Аймаар өлсөж байна ... юу ч хамаагүй идмээр байна. Энэ хархны идэш шиг юмыг хэн иддэг юм бэ? Гуйлгачин шиг. Хичнээн өлсөж байсан ч ийм юм хэзээ ч идэхгүй! хэзээ ч! Хэзээ ч үгүй!..... Үгүй ээ... үүнийг ч болтугай идье.

Есүс

Бага хүү гэдэс нь ихэд өлсөж гахайны идээд үлдээсэн хоолыг хүртэл идэж орхив.

Бага хүү

(гахайнд) пөөх! Та нар үнэхээр үүнийг амттай гэж иддэг үү? Ёстой гахай л юм даа. Та нар амт гэж юу болохыг ер нь мэдэх үү? ... ингэхэд би юу хийх ёстой вэ? Байз ... нээрээ, эцгийн минь гэрт тэр олон ажилчид өдөр бүр сайн идэж, идэх юм хүртэл үлддэг байсан гэтэл би энд суугаад иймэрхүү юм идээд байж байдаг. Тиймээ, эргээд гэртээ харьж ажилчидтай хамт ажиллаж амьдарсан ч яахав.

гэхдээ .. болохгүй ш дээ. Яаж би эцгийнхээ гэрт буцаж очиж чадах билээ? Би хэтэрхий тэнэг хүн шиг аашилсан. Амиа хичээсэн дээр нь байсан мөнгөө бүгдийг үрчихсэн. Үгүй ээ, гэртээ харья. Хариад эцгийнхээ ажилчин ч болтугай болгооч гэж гуйя. Би дэндүү том нүгэл үйлдэж уучлаач гэж хүртэл хэлж чадахгүй нь ...

Есүс

Нөгөөх бага хүү нь босоод эцгийнхээ байсан газар руу явжээ. Хол байдаг ч хүүгээ үргэлж хүлээн алсыг ширтэж байсан эцэг, хүүгээ хараад гүйн ирж хүзүүгээр нь тэврээд үнсэж гэнэ.





Эцэг	Хүү минь! Миний хүү! өө ... хэдэн жил болов оо? Сайн сууж байв уу? Хаагуур яваад ирэв?
Бага хүү	Аав аа, би мөнгө, цаг хугацаагаа үрэн таран хийж дэндүү тэнэг хүн шиг амьдарчээ. Эцэгтээ том нүгэл үйлдсэн тул над шиг амьтан хүү гэж дуудагдах эрх ч байхгүй. Зүгээр л энд амьдрангаа таны ажилчнаар амьдарч болох уу?
Эцэг	хөөе! хурдалцгаа! Хамгийн сайн хувцас авчираад хүүд минь өмсүүлж гарт нь бөгж зүүж хөлд нь гутал өмсүүл! тэр! Тарган тугалы авчираад нядал. Бүгдээрээ цуглараад идэж наргицгаая! Миний энэ хүү үхээд одоо амьдарлаа, би алдсан боловч одоо эргэж оллоо.
Зарц	юу гэсэн үг вэ?
Бусад хүмүүс	Харин тийм ээ. Юу гэсэн үг вэ, тарган тугал, юу вэ? Библийн цаг уу?
Есүс	Бүх ажилчид жаргалтайгаар тэр өдрийн орой найранд бэлджээ. Том хүү нь талбайд байж байгаад буцаж ирээд, гэртээ ойртох үед наргисан хөгжим дуу, бүжиглэх чимээ сонсогдов.
Том хүү	Юун хөгжим найр вэ, юу болоов?
Зарц	Дүү тань гэртээ буцаж ирсэн. Эрүүл саруул буцаж ирсэнд ихэд баярлаад эзэн тарган тугал нядалсан. Хурдан ороод дүүтэйгээ уулзана уу!
Том хүү	Юу гэнээ? Үгүй ээ! Тэр золигийг хармааргүй байна!
Есүс	Том хүү нь хөрөнгөө авч зугтаасан дүүд нь зориулж эцэг нь найр хийснийг сонсоод уурлав. Өөрөө буруу зүйл хийх юмуу зугтааж байсан удаагүй атал эцэг нь түүнд зориулж найр хийж байгаагүйд атаархжээ.
Том хүү	аав аа, би ингэж олон жил танд үйлчилж байна. Таны тушаалыг нэг ч удаа зөрчиж байгаагүй. Надад найзуудтайгаа хамт хөгжилд гэж нэг ишиг ч өгч байгаагүй шүү дээ. Энэ чинь шударга бус байна!
Эцэг	Хүү минь, чиний сэтгэлийг бүгдийг ойлгож байна. Чи бол үргэлж надтай хамт байдаг болохоор миний бүх зүйл бол бүгд чинийх. Харин чиний дүү үхээд амьдарсан. Би алдаад эргэж олсон учраас баярлан хөгжилдөх нь зохистой бус уу?
Есүс	Би та нарт хэлье. Мөн үүний адил, тэнгэрт гэмших шаардлагагүй зөвт 99 хүнээс илүү, гэмшээд буцаж ирсэн нэг нүгэлтэн байвал Бурханы тэнгэрэлч нарын оршихуйд баяр хөөр болно.

Өгүүлэгч

Есүсийн энэ яриаг сонссон хүмүүс сэтгэл нь тайвширч жаргалтай болов. Харин фарисайчууд үүнийг сонсоод юу ч хэлж чадахгүй, Есүсийг улам л үгүй хийхийг хүсэж байлаа.